

БҮЛЭГ III

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1 ИНФЛЯЦ

3.2 МӨНГӨ БА САНХҮҮГИЙН САЛБАР

ТОЙМ


Инфляц 2025 оны 2 дугаар улиралд 8.2 хувьд хүрч саарсан ч төв банкны зорилтоос өндөр хэвээр байна. Эдийн засгийн дотоод идэвхжил саарч, эрэлтийн инфляцын дарамт буурахын зэрэгцээ нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт өмнөх улиралтай харьцуулахад саарсан байна. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгаллаа. Арилжааны банкуудын зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсээр байна. Харин банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

47. Инфляц 2025 оны 2 дугаар улиралд саарч, төсөөллөөс бага гарав. Инфляц 2025 оны 6 дугаар сард 8.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар нэмэгдэхэд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 1.5 нэгж хувийг, тээврийн бүлэг 0.9 нэгж хувийг, хувцас, бөс бараа, гутлын бүлэг 0.5 нэгж хувиар нөлөөлж, голлох шалтгаан болсон байна.

Инфляцын 2.0 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 1.6 нэгж хувийг хүнсний бараа, 1.2 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 1.0 нэгж хувийг боловсролын үйлчилгээ бүрдүүлэв. Инфляц төсөөллөөс бага гарахад мах, махан бүтээгдэхүүний үнэ хүлээлтээс багаар өссөн, дулааны тарифыг нэмэхгүй шийдвэр гарсан зэрэг хүчин зүйлс нөлөөллөө.

48. Импортын болон дотоодын бараа, үйлчилгээний инфляц өмнөх онтой харьцуулахад өндөр байна. Импортын барааны инфляц 2025 оны 6 дугаар сард 5.0 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өсөж, нийт инфляцын 26 хувийг бүрдүүллээ. Импортын инфляцын 87 орчим хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутал, автомашин, шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2025 оны 6 дугаар сард 11.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.0 нэгж хувиар эрчимжиж, нийт инфляцын 74 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голлох нөлөөтэй байна. Тодруулбал, 2025 оны 6 дугаар сард үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 10.6 нэгж хувиар нэмэгдэж, инфляцын 4.0 нэгж хувийг бүрдүүлжээ. Үйлчилгээний үнийн

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн



өсөлт эрчимжихэд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээс, нийтийн хоолны үйлчилгээ, таксины төлбөрийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

49. Эрэлт, нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өмнөх улирлаас саарав. Хүнс, шатахуун, түлш, эрчим хүчийг хасаж тооцсон эрэлтийн (суурь) инфляц 2025 оны 2 дугаар улиралд 8.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар эрчимжсэн бол өмнөх улиралтай харьцуулахад 0.7 нэгж хувиар саарсан байна. Үүнд эдийн засгийн дотоод идэвхжил суларч байгаа нь нөлөөллөө. Эрэлтийн инфляц нийт инфляцын дийлэнх хэсгийг буюу 65 орчим хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 7.9 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар эрчимжсэн байна. Нийлүүлэлтийн инфляц эрчимжихэд өрхийн цахилгааны тариф өмнөх оны мөн үеэс 65 хувиар, хүнсний барааны үнэ 5.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

50. Хүнсний ба хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх оны мөн үеэс өссөн ч өмнөх улирлаас саарав. Хүнсний барааны инфляц 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 5.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 нэгж хувиар эрчимжсэн ч өмнөх улирлаас саарлаа. Нийт инфляцын 1.6 нэгж хувийг бүрдүүлсэн хүнсний инфляц өмнөх оны мөн үеэс эрчимжихэд мах, махан бүтээгдэхүүн болон ундааны үнийн өсөлт голчлон нөлөөлжээ. Тодруулбал, мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 8 хувиар, ундааны үнэ 10.5 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн, хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 9.3 хувь болж, өмнөх оны мөн


үеэс 4.8 нэгж хувиар өслөө. Хүнсний бус инфляц эрчимжихэд орон сууцны бодит түрээсийн үнэ өмнөх оны мөн үеэс 47 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, суудлын автомашины үнэ 2.9 хувиар болон хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 9.1 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлэв.

51. Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс буурсан бол хүнсний үнийн индекс өслөө. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүссэн халдлагын нөлөөгөөр 2024 оны 2 дугаар сараас хойш эрчтэй өсөөд байсан бол 2024 оны 8 дугаар сараас аажмаар буурч эхэлсэн. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2025 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 2,983 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 44 хувиар буурсан бол цар тахлын өмнөх үеэс 116 хувиар өндөр байна.

Хүнсний үнийн индекс 2025 оны 2 дугаар улирлын эцэст 128.0 болж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өслөө. Дэлхийн зах зээл дээр сүүн бүтээгдэхүүн, мах болон ургамлын тосны үнэ өссөн бол үр тариа, элсэн чихрийн үнэ буурсан байна. 2025 оны 6 дугаар сарын байдлаар Хятад, Солонгос, Киргизстан, Казакстан, Гүрж, Америк, Их Британи болон Евро бүсийн инфляц өссөн бол Орос, Япон, Турк, Шри-Ланк улсуудын инфляц буурсан байна.

52. Бодлогын хүү зохистой түвшинд байна. Төв банк 2025 оны 2 дугаар улиралд бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгаллаа. Бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүү 11.6 хувь байгаа нь бодлогын хүүний дундаж түвшинтэй


Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс



нийцтэй байна. Түүнчлэн 2025 оны 2 дугаар улиралд бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг бага зэрэг чангаруулах нөлөөтэй байв. Мөн бодит ханшийн зөрүүний мөнгөний нөхцөлийг чангаруулах нөлөө өмнөх улирлаас буурсан үзүүлэлттэй байна. Цаашид

шинээр олгосон зээлийн өсөлт, геополитикийн тогтворгүй байдал, тарифын бодлого зэрэг инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хэвээр хадгалагдаж байгаа тул бодлогын хүүг богино хугацаанд бууруулахгүй байх нь тохиромжтой байна.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ




МӨНГӨ БА САНХҮҮГИЙН САЛБАР

53. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт үргэлжлэн саарч байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 2 дугаар улирлын эцэст 3.7 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 28.2 нэгж хувиар буурлаа. Эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 7.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.9 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах 2.6 нэгж хувиар, гадаад валютын харилцах 2.5 нэгж хувиар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувиар тус тус бууруулах нөлөө үзүүлээ. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 18.0 нэгж хувийг дотоод цэвэр актив бүрдүүлсэн бол гадаад цэвэр актив 14.3 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ. Гадаад цэвэр активын бууралтад гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Харин дотоод зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсанаар дотоод цэвэр актив өсжээ.

54. Зээлийн өсөлт алгуур саарч байна. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар улирлын эцэст 42.2 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 27 хувьд хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 71 хувь буюу 29.8 их наяд төгрөгийг бизнесийн зээл, 29 хувь буюу 12.4 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 30.3 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар эрчимжсэн байна. Бизнесийн зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны зээл өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 26.1 хувиар, барилгын зээл өмнөх оны мөн үеэс 36.9 хувиар, хөдөө аж ахуйн зээл 84.3 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлжээ. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 19.6 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 18.6 нэгж хувиар саарсан байна. Цалингийн зээл хэрэглээний зээлийн өсөлтөд голлох нөлөөтэй хэвээр байна. Тодруулбал, цалингийн

Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд




зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өсжээ. Мөнгөний бодлогын хорооноос 2025 оны 1 болон 2 дугаар улирлын ээлжит хуралдаануудаар тэтгэврийн зээлд зохицуулалт хийж, шинээр олгох зээлд өр, орлогын харьцаа мөрдөх болсноор тэтгэврийн зээлийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 5.9 хувьд хүрч саарав.

55. Шинээр олгосон зээлийн өсөлт бизнесийн зээлийн хувьд өндөр хэвээр байгаа бол хэрэглээний зээлийн хувьд саарах хандлагатай байв. 2025 оны эхний хагаст банкны салбарын шинээр олгосон зээлийн нийт хэмжээ 32.8 их наядад хүрч, өмнөх онтой харьцуулахад 4.9 их наяд төгрөгөөр буюу 17.6 хувиар өслөө. Шинээр олгосон зээлийн 66.2 хувийг бизнесийн зээл, 33.8 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. 2025 оны эхний хагасын байдлаар шинээр олгосон бизнесийн зээлийн жилийн өсөлт 23 хувьд хүрч, өсөлтийн хурд 27 нэгж хувиар саарлаа. Бизнесийн шинээр олгосон зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, барилгын салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2025 оны эхний хагаст 8.2 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 23 нэгж хувиар буурчээ. Шинээр

олгосон хэрэглээний зээлийн өсөлтийг хадгаламж барьцаалсан зээл бүрдүүлж байна. Төв банкнаас 2025 оны 2 дугаар улиралд тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээлд өр орлогын харьцаа мөрдөх зохицуулалтыг хэрэгжүүлж, зээл олгох нөхцөлийг чангаруулснаар тэтгэврийн зээл олголт өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буурав.

56. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс өслөө. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар нэмэгдсэн байна. Чанаргүй зээлийн 18.9 хувийг цалин, 17.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 15.6 хувийг барилга, 13.5 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 10.6 хувийг уул уурхай, олборлолтын зээл бүрдүүлж байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд чанаргүй цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 142.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин уул уурхайн салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар буурч, зээлийн чанарт эерэг нөлөө үзүүлжээ. Улмаар чанаргүй зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 4.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд



57. Нийт хадгаламжийн өсөлтийн дийлэнхийг иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлт бүрдүүлж байна. Банкнуудын нийт хадгаламж 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 27.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 23.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 19.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өслөө. Харин байгууллагын нийт хадгаламж 4.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар тус тус өссөн байна. Төгрөгийн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 11.6 хувьтай, өмнөх оны орчимд байсан бол валютын хадгаламжийн хүү 3.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламж өсөлттэй хэвээр байгаа ч өсөлтийн хурд саарах хандлагатай байна.

58. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс буурав. Гадаад валютын харилцах ба хадгаламжийн мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хэмжээ 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 22.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурсан бол өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар өссөн байна. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс буурахад гадаад валютын харилцах 18.9 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

59. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү бодлогын хүүний орчимд байна. 2025 оны 2 дугаар улиралд мөнгөний бодлогын хүү 12 хувьд хадгалагдсан бол банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү мөн 12 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

60. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүү. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2025 оны 2 дугаар улиралд 17.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар өсжээ. Харин бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.7 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.7 нэгж хувиар тус тус өссөн байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө. Бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос өсөхөд зээлийн хүү хадгаламжийн хүүнээс өндрөөр өссөн нь нөлөөлөв.

61. Зээлийн тэлэлт сэргэх хандлагатай байна. 2025 оны 2 дугаар улиралд нийт зээл дотоодын нийт бүтээгдэхүүний¹⁰ 46.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.4 нэгж хувиар өссөн байна. Зээлийн тэлэлт 2022-2023 онд саарсан байсан бол 2023 оны сүүлийн хагасаас сэргэж эхэллээ. Мөн банкны салбарын нийт зээл ба хадгаламжийн харьцаа 2025 оны 2 дугаар улиралд 1.53 (153 хувь) болж, өмнөх оны мөн үеэс 0.14 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.09 нэгж хувиар тус тус өсжээ. Уг харьцаа өсөхөд банкны салбарын зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Зээл ба хадгаламжийн харьцаа өндөр болсноор хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

62. Банкны салбарын ашигт ажиллагаа тогтвортой хэвээр байна. Банкны салбарын активын өгөөж 2025 оны 2 дугаар улиралд 2.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурлаа. Хэдийгээр банкны салбарын активын өгөөж өмнөх оны мөн үеэс бууралттай байгаа ч 2 хувиас дээш хадгалагдаж байгаа нь банкнуудын ашигт ажиллагаа өндөр байгааг илтгэж байна. Банкуудын ашигт ажиллагаа тогтвортой байхад эх үүсвэр талаас иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлт голлох нөлөө үзүүлээ.

63. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр хэвээр байна. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 573 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 6.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 45.4 хувиар өссөн байна. Нийт олгосон зээлийн 92.9 хувийг иргэдэд, 7.1 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлжээ. 2025 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 88.5 хувь буюу 2.5 сая харилцагч финтек зээлийн үйлчилгээгээр нийт 1.9 их наяд төгрөгийн зээл авсан байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жинлэсэн дундаж хүү сарын 3.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсжээ.

¹⁰ ЭЗХЯ-ны нэрлэсэн ДНБ-ий 2025 оны төсөөллийг ашиглав.

МӨНГӨНИЙ СЕКТОР



Хүснэгт 3.1 Санхүүгийн салбарын эмзэг байдал

		Зээлийн тэлэлт	Хөрөнгийн чанар	Ашигт ажиллагаа	Төлбөр гүйцэтгэх чадвар	Хөрвөх чадвар
		Нийт зээл/ДНБ	Чанаргүй зээл/Нийт зээл	Банкны активын өгөөж	Зээл/Хадгаламж	Хөрвөх актив/Богино хугацаат өр төлбөр
2020	I	44.8	10.8	0.3	123	40.9
	II	45.4	11.1	1.2	114	38.1
	III	45.4	11.4	1	104	38.6
	IV	45	11.8	0.5	95	48.0
2021	I	39.1	11.5	1.1	95	48.0
	II	42.4	10.3	2.2	100	53.3
	III	44.8	9.9	1.5	105	48.8
	IV	46.2	10	0.7	110	53.3
2022	I	39.9	9.7	2	123	44.2
	II	42.4	9	3.5	128	45.1
	III	41.5	11.2	1.3	134	42.0
	IV	40.1	9.2	2.8	127	56.7
2023	I	32.3	9.6	2.4	122	48.3
	II	35.6	8.7	2.7	131	49.0
	III	36.3	8.5	2.4	131	50.7
	IV	38.1	7.5	2.6	124	57.8
2024	I	36.1	7.1	2.8	129	57.2
	II	41.5	5.9	3.4	139	51.7
	III	43.7	5.7	2.3	141	49.2
	IV	45.9	5.1	2.6	139	52.0
2025	I	42.9	5.3	2.4	144	49.2
	II	46.9	4.9	2.1	153	43.2

Тэмдэглэл: Хөрвөх активыг касс дахь бэлэн мөнгө, төв банк дахь харилцах ба хадгаламж (төгрөг, валют), төв банкны үнэт цаас болон төв банк дахь бусад хадгаламжийн нийлбэрээр тооцов. Богино хугацаат өр төлбөрт харилцах болон хугацаатай хадгаламж, бусад санхүүгийн байгууллагуудын, банк хоорондын, гадаадын байгууллагын, болон төрийн байгууллагын өр төлбөрөөр тооцсон болно.

Нийт зээл ба ДНБ-ий харьцааг тооцоход ЭЗХЯ-ны 2025 оны нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийг ашиглав

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик